



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 559

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Геологийн судалгаа-шинжилгээний төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, нийт 8,363,500.00 (найман сая гурван зуун жаран гурван мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, "Геологийн судалгаа-шинжилгээний төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Т.Бүжинлхам, "Баянчандмань АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай;

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002126  
25-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

"ГЕОЛОГИЙН СУДАЛГАА - ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА,  
 ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Балансад бүртгэлтэй байгууллагын нэр           | Хөрөнгийн нэр, марк   | Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд он | Улсын дугаар | Арлын дугаар | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Балансын үнэ /хуримдлагдсан элэгдэл/ (төгрөг)                         | Шинэчлэн тогтоосон хугацаа (жилээр) | Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг) | Хүлээн авах байгууллага  |
|----------|------------------------------------------------|-----------------------|------------------------------|--------------|--------------|------------|-------------|-----------------------------------------------------------------------|-------------------------------------|--------------------------------------|--------------------------|
| 1        | "Геологийн судалгаа- шинжилгээний төв" ТӨААТҮГ | Чиргүүл /HEX9391XX Y/ | 1980/ 2009                   | 91-76 АЧ     | 300007       | 1          | ш           | 8,363,500.00                                                          | 3                                   | 3,000,000.00                         | "Баянчандмань АЗЗА" ТӨХК |
| Нийт дүн |                                                |                       |                              |              |              |            |             | 8,363,500.00<br>(найман сая гурван зуун жаран гурван мянга таван зуу) |                                     | 3,000,000.00<br>(гурван сая)         |                          |